

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН БҮРЭН ДУНД  
СУРГУУЛИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ

2017-2025 ОН

БАТЛАВ. ЗАСАГ ДАРГА



С. МӨНХБААТАР

## ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН БҮРЭН ДУНД СУРГУУЛИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР


Сургууль нь сумын боловсролын үзэл баримтлал үйл ажиллагааг хэрэгжүүлэгч мэргэжлийн алба мөн. Сургууль нь Монгол улсын Засгийн газар, БСШУСЯ, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллааны хөтөлбөр бодлогыг хэрэгжүүлж тэдгээрээс боловсролын талаар гаргасан шийдвэр өгсөн чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага мөн тул өөрийн дотоод дүрэм журамтай байна.

### Үндэслэл

#### Энэхүү хөгжлийн хөтөлбөрийг

1. Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр
2. Боловсролын тухай хуулиуд
3. Төрийн албаны болон Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
4. Боловсролын сайдын тушаалууд
5. Боловсролын хөгжлийн хөтөлбөрүүд
6. Сургуулийн дотоод журмыг үндэслэл болгосон бөгөөд дээрх хууль тогтоомжуудын хүрээнд сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг мөрдлөг болгон явуулна

## МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГА



Сургуулийн удирдлага мэргэжил зохицуулалтын үйл ажиллагаа нь аймгийн БСУГ, сумын ЗДТГ-ын удирдлага хяналт санхүүжилт

# **ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН БҮРЭН ДУНД СУРГУУЛЬ**

## **1. СУРГУУЛИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО**

ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХҮНДЭТГЭН СУРАХ ТЭМҮҮЛЭЛИЙГ ӨРНҮҮЛСЭН, БҮТЭЭЛЧ 1СЭТГЭЛГЭЭ ХАМТАЧ АЖИЛЛАГААГ ДЭМЖИН ЦОГЦОЛБОР СУРГУУЛЬ БОЛОХ

## **2. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО**

СУРАГЧ СУРАЛЦАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ШИНЭЛЭГ СЭТГЭЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЖ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ШИНЭ АГУУЛГА ХЭЛБЭРЭЭР БАЯЖУУЛЖ СУРГАЛТЫН ШИНЭ ТЕХНОЛОГИЙГ ЭЗЭМШСЭН МАТЕМАТИК, АНГЛИ ХЭЛНИЙ ГҮНЗГИЙРҮҮЛСЭН СУРГАЛТТАЙ БҮТЭЭЛЧ СУРГУУЛЬ БОЛОХ

### **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ**

Сургуулийн үйл ажиллагааны стратеги нь сумын боловсролын бодлого боловсруулах түүнийг хэрэгжүүлэхэд туслах сумын иргэдийн боловсролын түвшинг ахиулахад чиглэгдэнэ.

### **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ**

1. Төрөөс боловсролын талаар явуулж байгаа бодлогыг хэрэгжүүлэхтэй уялдуулан сумын боловсролын бодлого боловсруулан хэрэгжүүлэхэд Засаг даргад тусална.

2. Сумын иргэдийн боловсролын түвшинг ахиулах
3. Багшлах боловсон хүчнээр хангаж мэргэжлийг дээшлүүлэх
4. Суралцагсдад боловсролын стандартыг хангасан сургалт явуулж цаашид суралцах бэлтгэл суурьтай болгох
5. Багш сурагчдын ажиллах суралцах таатай орчныг бүрдүүлэх
6. Суралцагсдын дотуур байрны хангалт, тохижилт, соёлжилтын ажлыг бүрэн шийдвэрлэх

### ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТУУД

1. Сумын иргэдийн боловсролын түвшинг зөв тодорхойлж боловсролын бодлого боловсруулах
  - Сумын иргэдийн боловсролын түвшинд шалгалт хийж судалгаа дүгнэлт гаргах
  - Судалгаа дүгнэлтээс үндэслэн сумын боловсролын бодлого боловсруулна
  - Үйл ажиллагааны зардал санхүүжилтийг тодорхойлж эх үүсвэрийг тогтооно.
  - Боловсролын бодлогыг хэрэгжүүлэхэд Засаг даргын тамгын газар, багийн засаг дарга нийгмийн бодлого, АББ хариуцсан хүмүүс болон холбогдох байгууллагын чиг үүргийг тогтооно.
2. Сургалтын хэвийн ажиллагаа нөхцлийг бүрдүүлэх
  - Мэргэжилтэй, чадвартай багшаар хангах
  - Багш нарын мэргэжлийг системтэй дээшлүүлэх
  - Ажлын байрны нөхцөлийг сайжруулах
  - Сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, гэрэл цахилгаан, халаалтыг хэвийн болгох
  - Кабинет, лаборатори, мэдээлэлийн хэрэгслийг бололцооны хирээр шаардлагын түвшинд бэлтгэх
  - БСШУЯ Азийн Хөгжлийн Банкны БСХХ-ийг хэрэгжүүлэх бүсийн төв сургуулийн хэмжээнд хүрч бүсийн сургуулиудын удирдах ажилтан багш нарын сургалтыг зохион байгуулах нөхцөлөөр хангах
3. Сургуулийн удирдлага, үйлчилгээгээр хангах
  - Багш нарын ажлыг дүгнэх, шагнал урамшлын систем боловсруулах
  - Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах аж амьдралд нь туслах
  - Өмч хөрөнгийн захиран зарцуулах хяналт тавих, эдэлгээг уртасгах арга хэмжээ авах
  - Сургуулийн удирдах ба сурган хүмүүжүүлэх зөвлөл сурагчдын олон нийтийн байгууллагуудыг ажиллуулж тус тусын шугамаар ажлаа тайлагнах
  - Сургуулийн захирал нь сургуулиа төлөөлөн гадаад, дотоод харилцааг зохицуулна

- Захирал нь боловсролын ажлын талаар сумын Засаг даргатай жилийн хугацаагаар ажил төрлийн холбоотой ажиллана.
4. Иргэдийн боловсролын тувшинд өөрчлөлт гаргах
- Бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах зорилгоор нэгдсэн болон хэсэгчилсэн сургалт явуулах
  - Сургууль завсардалтыг зогсоох талаар бодлого боловсруулж мөрдөх
  - Завсардсан хүүхдийг албан бус сургалтанд хамруулах
  - Насанд хүрэгчдийн дунд эчнээ сургалт явуулах хөтөлбөр боовсруулах
  - Холбогдох хөтөлбөр, хууль тогтоомжийг сурталчилан таниулах
  - Сургуулийг иргэдэд ойртуулах зорилгоор зайны сургалтын аль нэг хэлбэрийг сонгох
- б.Суралцагсдын сурлагын чанарт өөрчлөлт гаргах
- Өөрийн сургуулийн сургалтанд хоцрогдож яваа Англи хэл.Математикийн боловсон хүчин бэлтгэхэд анхаарах.материаллаг нөхцөл лаборатороор хангах
  - Сургалтын чанараар аймагтаа тэргүүлж.онцлог хичээлийн олимпиадууд,урлаг спортын уралдаан тэмцээнд өндөр амжилт гаргах
  - Мэргэжлийн өндөр чадвартай багш нарын тоог нэмэгдүүлэх
  - Ээлжит хичээлийн бэлтгэлийг шаардлагын хэмжээнд хангах
  - Сургалтанд тэргүүний дэвшилттэй арга барилыг нэвтрүүлэх
  - Бусад ЕБС.Их дээд сургуулиудтай шефийн холбоотой туншлэлийн гэрээтэй ажиллах
  - Суралцагсдын суралцах бүтээлч идэвхийг өрнүүлэх мэдлэг чадварын хэрэгцээ бий болгох
  - Суманд байгаа чадвартай мэргэжилтэн боловсон хүчнийг сургалтанд ашиглах
  - Эцэг эх.иргэд бйагууллага аж ахуйн нэгжүүдийн оролцоо дэмжлэгийг сургалтанд өргөн ашиглах
  - Сургалтын ажлыг сурган хүмүүжүүлэх судалгаа шинжилгээнд тулгуурлан яюуулах
  - Суралцагсдад сурах арга барил эзэмшүүлэн бие дааж сурч боловсрох бололцоо бий болгох ,багш сурагчдыг сурах бичиг мэдээллийн хэрэгслээр хангах

**ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН БҮРЭН ДУНД СУРГУУЛИЙН 2025 ОН ХҮРТЭЛХ  
ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

## **Одоогийн байдал**

Эрдэнэдалай сумын бүрэн дунд сургуулийн 38 бүлэгт өдрөөр 1164 сурагч дүйцсэн хөтөлбөрөөр 4 сурагч суралцаж байна. 59 багш 5 удирдах ажилтан 38 ажилчид үүрэг гүйцэтгэн бага суурь боловсролын хамран сургалтыг 100 хувьд хүргэн сургуулийн хүүхдийн тоо тойргийн хүүхдийг хамран жилээс жилд өссөөр байна. Багш нарын 98,4 хувь нь буюу 58 багш боловсролын чиглэлээр их дээд сургуульд төгссөн мэргэжлийн багш ажиллаж 55,5 хувь буюу 35 багш мэргэжлийн зэрэгтэй. Боловсролын тэргүүний ажилтан 16 багш ажиллаж байна.

Дотуур байранд суухаар хүсэлт ирүүлсэн сургачдыг 100 хувь хамран 130 гаруй хүүхэд тогтмол байранд сууж шалтгаангүйгээр сургууль завсардалт бүрэн арилсан. Төрийн ба төрийн бус байгууллага хандив тусламжаар сургуулийн шаардлагатай техник хэрэгслийг тавилага тоног төхөөрөмжийг үе шаттайгаар ханган хичээлийн 2 байранд ариун цэвэрийн дотор байгууламжтай болж сургуулийн гал тогоонд цэвэр усны оруулалтыг хийж шийдвэрлэсэн.

### **НЭГ. Сургуулийн эрхэм зорилго. зорилт**

**Эрхэм зорилго: ХҮҮХДИЙН ЭРХИЙГХҮНДЭТГЭН СУРАХ ТЭМҮҮЛЭЛИЙГ ӨРНҮҮЛСЭН, БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭ ХАМТАЧ АЖИЛЛАГААГДЭМЖИН ЦОГЦОЛБОР СУРГУУЛЬ БОЛОХ**

#### **Зорилт:**

1. БСШУСЯ-наас ЕБС-ийн сурлагын чанарыг дээшлүүлэх талаар тавьж буй зорилгыг хэрэгжүүлж, математик, монгол хэлний хичээлийн сургалтыг сайжруулахад ахиц өөрчлөлт гаргаж суралцагсадад хичээлээс гадуур англи хэлний мэдлэг олгоход түлхүү анхаарч ажиллана.
2. ТБУС-ын тухай хуулийг хэрэгжүүлж сургуулийн бүтээгдхүүн нийлүүлэлтийн чанарын сайжруулна.
3. Бага, дунд, ахлах боовсролын стандартыг хэрэгжүүлж сурагчдын сурах арга барилыг нэмэгдүүлнэ
4. Багш нарын мэргэжлийг дээшлүүлэхэд сургалтын олон хэлбэрийг ашиглаж мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар санаачлагатай ажиллана.
5. Сургалтын менежерийн үүрэг хариуцлагыг өндөржүүлж, заах аргын нэгдлийн ажлыг чанаржуулах замаар
6. Хүүхдэд ээлтэй сургууль зорилтыг хэрэгжүүлж 1 сургууль 10 клуб аяныг өрнүүлж үр дүнд хүрнэ.
7. Сургалтын тоног төхөөрөмж. техник хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлж. сургуулийн номын сангийн үйл ажилагааг сайжруулахад гадны байгууллагын хандив тусламжтайгаар хэрэгжүүлнэ.
8. Сургуулийн сурагчдын дотуур байрны үйлчилгээг сайжруулж эцэг эхийн тусламж дэмжлэг, Дэлхийн зөн ОУБ

бусад төслийн санхүүжилтээр хэрэгжүүлж ажилласнаар сургууль завсардалтыг арилгана

### **ХОЁР.Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

Сургуулийн 440 хүүхдийн болон бага сургуулийн хичээлийн байруудад ээлж дараалалтай засвар хийж тохилог орчинг бүрдүүлэх

Хичээлийн танхим дотуур байрны барилгуудын халаалтын системийн бүх холбох хэрэгсэл, тоног төхөөрөмжийг засварлан нэгдсэн системд холбох

Хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон орчны стандартын шаардлага хангасан ширээ сандал, самбар бусад тавилга төхөөрөмжөөр бүх ангийг бүрэн хангана.

Улс аймгийн бүсийн төв сургуулийн орчин үеийн стандартын шаардлагыг бүрэн хангасан.математик.англи хэлний хичээлээр гүнзгийрүүлсэн ба төрөлжсөн сургалт явуулдаг цогцолбор сургуулийн түвшинд хүрч ажиллана Сургуулийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх өөрийн байгууллагын үйл ажиллагааг өндөржүүлж багш нарын нийгмийн баталгааг хангах ,тэдний ажиллах таатай орчинг сайжруулахад онцгой анхаарах

Сургалтын байгуулагад/сургуульд/ ханадах эцэг,эх,албан газардөр захиргаа хууль хяналтын байгууллагын оролцоог нэмэгдүүлж хамт олон нийтийн ажиллах шинэ арга хэлбэрийг нэвтрүүлснээр гэмт хэрэг,хэв журмын зөрчилгүй хмат олон болно.

Сургуулийн өмнөх боловрол олгох.сургуульд орох бэлтгэл сургалтанд хүүхдийг бүрэн хамруулахын зэрэгцээ сургалтыг сургууль цэцэрлэгийн багш нарын хамтын үйл ажилагааг боловсронгуй болгоно.

Суралцагсдын авъяасыг хөгжүүлэх дугуйлан.секцийн үйл ажилагааг чанаржуулж тэдний хэрэгцээнд тохирсон хичээлээс гадуур мэргэжил олгох сургалтыг зохион байгуулж явуулах.

Малчдын хүүхдийг дотуур байранд тохитой амьдрах нөхцлийг бүрдүүлж байранд суух шаардлагатай хүүхдийг 100 хувь хамарч сургууль завсардалтыг бүрэн арилгаж сурах боломжоор хангана

Багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн оюутнуудтай сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх, ажиллах нөхцөлөөр бүрэн хангах болон бусад олон хэлбэрийг ашиглаж сургуулиа нутгийн мэргэжлийн багшаар хангах болон бусад олон хэлбэрийг ашиглаж сургуулиа нутгийн мэргэжлийн багшаар хангах.багшлах боловсон хүчний нөөцийг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай хийж хэрэгжүүлнэ.

Бүх хичээлийг мэргэжилтэй багш нараар заалгах боломжийг нэмэгдүүлэх үүднээс хөрвөх чадвартай багшийн тоог нэмэгдүүлэхийн тулд холбогдох байгууллагатай хамтран шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Багш нарын сургалтын шинэ арга барилыг бүтээлчээр эзэмшүүлэхэд бүх талын нөхцөл боломжийг хангаж.технологи арга зүйн болон “Багшийн хөгжлийн төв”-дэд эрдэм шинжилгээний болон судалгааны ажил



хийх,илтгэл,гарын .багшийн бүхий л үйл ажилагааны чадавхийг нэмэгдүүлнэ.

Албан бус арга замаар бичиг үсгийн анхан болон суурь боловсрол олгох ажилд дүйцсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж боловсрол эзэмшээгүй иргэдэд зохих шатны суурь бүрэн дунд боловсролыг нөхөн олгох Өсвөр үеийнхэнд ардын уламжлалт урлагийг өвлүүлэх ялангуяа уртын дуу.морин хуурыг нийтийн хүртээл болгоход хичээл ба хичээлээс гадуурх сургалтын бүхий л үйл ажиллагааг чиглүүлж ажилласнаар энэ талаар улс,аймгийн хэмжээнд тэргүүний сургууль болох

Сургуулийн орчны стандартыг сайжруулах ,өсвөр үеийнхэнийг эрүүл мэнд сурч хүмүүжих таатай орчин бүрдүүлэх зорилгоор сургуулийг цэцэгжүүлэх ба цэцэрлэгжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх

Сургуулийн номын сангийн фондын баяжилтыг жил бүр хийж номын санг мэдээлэл сурталчилгааны төв болгох зорилгоор засвар тохижилтын ажлыг жил бүр хийж.ширээ сандал.тавилга төхөөрмж.техник хэрэгслээр бүрэн тоноглож тогтмол ашиглана.

## СУРГУУЛИЙН ЗАХИРГАА

### СУРГУУЛИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ:

1-р шатны үнэлгээг 2017 он

2-р шатны үнэлгээг 2020

Дотоод хяналт шалгалтыг жил бүр хийх

Хөндлөнгийн үнэлгээг 2 жил дутам хийх /Аймгийн БСУГ, БСШУЯ/

### СУРГУУЛИЙН ЗУУОТ шинжилгээ

<u>Давуу тал</u>	<u>Сул тал</u>
<ul style="list-style-type: none"><li>• Бүсийн болон тойргийн сургуулийн хүрээнд хамран сургалт сайн явагдаж хүүхдийн тоо жил бүр өсч байгаа..</li><li>• Мэргэжлийн багшаар 100% хангагдсан.</li><li>• Ахлах дунд анги нэг ээлжинд шилжсэнээр нэмэлт хичээл сонгон дугуйлан хичээллэх нөхцөл сайжирсан</li><li>• Гадаад дотоодын уралдаан тэмцээнээс шагнал авагчидын тоо нэмэгдэж хөнгөн атлетик сагсан бөмбөгөөр хичээлэгчидийн тоо нэмэгдсэн</li><li>• ЭЕШ өгөгчдийн амжилт өсч их.дээд сургуульд олноор элсэх болсон</li><li>• Төгсөгчид орон нутагтаа тогтвортой ажиллах боломж дээрдсэн</li><li>• 3 удаа гадаадын сайн дурын мэргэжилтэн /ЭТК/ авч ажиллуулж гадаад хэлний багш нарынхаа болон сурагчдын хэлний мэдлэг чадварыг сайжруулах ажил</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>• Хичээлийн А,В байрны барилга их засварт орох шаардлагатай болсон</li><li>• Дотуур байрны барилгын чанар муудсан дулааны алдагдал их ариун цэвэрийн байгууламжгүй</li><li>• Хичээлийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж дутмаг</li><li>• Хүүхэд бүрийн авьяасыг илрүүлэх, хөгжүүлэх дугуйлан секц хангалттай ажиллахгүй байгаа</li><li>• Багшийг урамшуулах санхүүгийн төсвийн боломжгүй</li><li>• Багшийн цалин хөлс амьдралд хүрэлцдэггүй,цалингийн зээлээр нийгмийн асуудлаа шийддэг</li><li>• Интернетийн хүчин чадал, хурд удаан</li><li>• Багш нарын хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэх материалын төсөв санхүү хүрэлцээгүй</li><li>• Олимпиад, тэмцээн уралдаанд хүүхдийг олноор тээвэрлэхэд тээврийн зардал хангалтгүй.</li></ul>

<p>санаачлан хийсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>• 24 цагийн цахилгааны эх үүсвэртэй</li> <li>• Интернетэд холбогдсон</li> <li>• Зам харилцаа сайн хөгжиж долоо хоногт дөрвөн удаа автобус явдаг болсон</li> <li>• Малчдын хүүхэд сурч, амьдрах дотуур байртай.</li> <li>• Сургуулийн эдэлбэр газарыг бүрэн хашаажуулж хүүхдийн аюулгүй байдалыг хангасан</li> <li>• Бүх мэргэжилийн чиглэлээр боломжийн хэрээр байгуулсан хичээлийн кабинеттай</li> <li>• Хүүхдийн дотуур байрны гал тогоо үдийн цайны гал тогоо тус тусдаа хоол үйлдвэрлэл явуулах боломжтой</li> <li>• Шинээр ирсэн багш нарыг орон сууцаар ханган ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг</li> </ul>	
<p style="text-align: center;"><b><u>Боломж</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх замаар бага үнэтэй сургалтын хэрэглэгдэхүүн авах</li> <li>• ЕБС хуулиар хандив тусламж авах нөхцөл хуульчлагдсан</li> <li>• Иргэдэд өдрийн сургалтаас гадна дүйцсэн хөтөлбөрөөр суурь бүрэн дунд боловсрол олгох</li> <li>• Бага ангийн сурагчидад өдөр өнжүүлэх бүлэг хичээлүүлэх</li> <li>• Сум дундын нэгдсэн эмнэлэгтэй учир эрүүл мэндийн үйлчилгээ авах</li> <li>• Үүрэн телефоны бүх суваг шилэн кабелийн шугамтай</li> </ul>	<p style="text-align: center;"><b><u>Саад бэрхшээл</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Аймаг, хоттой холбогдсон засмал замгүй машины эвдрэл их.хугацаа их алддаг</li> <li>• Хуурайшилт ихээр үүсч элс нэмэгдэн ногоон байгууламж бий болгох нөхцөл тааруу</li> <li>• Төсвийн хүрэлцээ муу сургуулийн бүх байранд урсгал засвар хийх хөрөнгө бага</li> </ul>

**Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын сум хөгжүүлэх зорилтын хүрээнд  
2020 он хүртэл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд бүрэн дунд сургуулийн  
Хөгжлийн бодлого төлөвлөлт**

Д/д	Хийх ажил	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
	<b>1. Сургуулийн барилга байгууламж шинээр барих</b>									
1	Ариун цэврийн байгууламжийг үе шаттайгаар шийдвэрлэх									
2	Сургуульд хүүхдийн автобус бий болгох									
3	Уурын зуухнуудыг нэгтгэн төвлөрсөн халаалттай болгох									
4	Багш нарын орон сууц барих									
	<b>2. Барилга байгууламж засварлах</b>									
1	440 хүүхдийн хичээлийн байрны засварын зураг төсөв гаргуулах									
2	440 хүүхдийн хичээлийн байранд их засвар хийх									
3	Дотуур байрны засварын зураг төсөв хийлгэх									
4	Дотуур байрны их засвар хийлгэх									
5	Дотуур байрны ундны ус цэвэршүүлэх									
6	Б байр спорт залны өмнөх талбайг цэцэрлэгжүүлж сүүдрэвчтэй болгох									
7	Дотуур байрны үүдэнд тоглоомын талбай бий болгох засварлах									
8	Дотуур байрны ариун цэврийн байгууламжийг сайжруулах									
9	Мэргэжлийн кабинетуудын тоог нэмэгдүүлж засварлах									
10	Сургуулийн орчныг тохижуулах ерөнхий зураг гаргах									
11	Хүндэтгэлийн өргөө гэртэй болох									
12	Чийрэгжүүлэх танхим бий болгох									

Жич: Дундговь аймгийн Боловсролын газраас боловсруулсан багш нарын мэргэжил боловсролыг дээшлүүлэх сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, тоног төхөөрмжөөр хангах, Монгол улсын засгийн газраас сум хөгжүүлэх үйл ажиллагааны талаар дэвшүүлсэн 2020 он хүртэлх зорилтоос тусгасан.



